



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 07 сарын 18 өдөр

Дугаар 1/357

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 45.2 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Зорилтот жил болгон зарлах тухай” 12/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны “Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг “Өвөрхангайд үйлдвэрлэв” худалдааны төвд сонгон авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.


Ажлын хэсгийн ахлагч: Н.Дулам -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа, үйлчилгээний бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: Д.Нансалмаа -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Худалдаа, нийтийн хоол, үйлчилгээ, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Ууганбаяр -Өвөрхангай аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхимын салбарын дарга (Зөвшилцсөнөөр)

2.Худалдааны төвд чанар, стандартад нийцсэн хаяг, шошго, сав, баглаатай бүтээгдэхүүн нийлүүлэх ажлыг сайтар зохион байгуулахыг ажлын хэсэг (Н.Дулам)-т даалгасугай.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

011100811